



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

Журмын заалтад өөрчлөлт
оруулах тухай


Монгол Улсын “Засгийн газрын тухай” хуулийн 24.2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6.1 дэх заалт, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 79 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 336 дугаар тушаалаар баталсан “Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам”-ын 3.2.3, 4.1.1, 4.2.3, 5.1 дэх заалтын “Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс ... гэснийг ... Эрүүл мэндийн хөгжлийн төв гэж өөрчилсүгэй.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080293